

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-15</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2024.08.15-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	<i>5-7</i>
<i>2. “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>7-15</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 16-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 24 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Жаргалан, Д.Цогтбаатар, Р.Эрдэнэбүрэн;
Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Г.Хосбаяр.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2024.08.15-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга З.Хүслэн, ахлах шинжээч Б.Мөнхбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төсөл болон Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Б.Батбаатар нараас ирүүлсэн албан бичгүүдийг тус тус танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Б.Батбаатар, П.Сайнзориг, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, П.Сайнзориг нараас дэд хорооны бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй байх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, П.Сайнзориг нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул дэд хорооны бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй байхаар тогтов.

“Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин үг хэлж, 1 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./13:04/

Хуралдаан 13 цаг 04 минутад завсарлаж, 14 цаг 24 минутаас үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссан тухай мэдэгдэв./14:25/

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Б.Батбаатар нараас ирүүлсэн саналын дагуу дэд хорооны гишүүнд нэр дэвшигч тус бүрээр илээр санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Х.Тэмүүжин нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дэмжсэнээр тооцож, 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дэмжсэнээр тооцож, 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: 4. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дэмжсэнээр тооцож, 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 14
Бүгд: 18
22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 13
Бүгд: 18
27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 55 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их Засаг” танхим,
12 цаг 24 минут

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар, Чинбаатарын Анар, Батын Батбаатар, Энхбатын Болормаа, Хажсекберын Жангабыл, Нанзадын Наранбаатар, Пүрэвжавын Сайнзориг, Өлзийхүүгийн Шижир, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Энхбаяр, Лутаагийн Энхнасан, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын гишүүд хүрэлцэн ирснээр 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа.

Нэгдүгээрх нь, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай” хэлэлцээрийн төсөл /Засгийн газраас 8 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна./

2 дахь нь, “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар

хамтран ажиллах тухай” хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай” хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Энхбаяр сайд танилцуулна. Энхбаяр сайдын микрофоныг өгчихье.

Ж.Энхбаяр: Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, 2 улсын иргэдийн нийгмийн харилцаанд харилцан тэгш эрхтэй байх, тухайн улсын иргэд тэрний нэгэн адилаар тэтгэвэр тэтгэмж авах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж ирлээ.

Одоогийн байдлаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар улс Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Чех Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулж, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэвэр тогтоолгон авах, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцсон хэлэлцээрийг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Австри Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр шинээр байгуулах Оросын Холбооны Улстай

байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэх асуудлаар тус тус хэлэлцээ хийж байна. Олон улсын гэрээний тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсын талтай Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсоноор хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд зөвшилцөхөөр хүргүүлсэн болно.

Мөн хэлэлцээрийн төслийг Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн дэмжиж, улмаар 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн ам, нийгмийн хамгааллын сайдад хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг олгосон байна. Энэхүү хэлэлцээр нь нийгмийн даатгалын хуулиудад зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д зааснаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм.

Уг хэлэлцээр батлагдаж хэрэгжсэнээр 2 улсын иргэд Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсад ажилласан, шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн тооцуулж өндөр насны тэтгэвэр тогтоолгох, мөн Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Казахстан Улсаас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдэж, нийгмийн баталгаа нь сайжрах юм.

Хэлэлцээрийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хэлэлцээр батлагдсанаар бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт хөрөнгийн эх

үүсвэр шаардагдахгүй юм. Хэлэлцээрийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга, Басангийн Батжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Зоригтын Хүслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэлтсийн дарга, Бямбаагийн Мөнхбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ахлах шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгөөрэй. Жангабыл гишүүнээр тасалъя. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хэлэлцээр байгуулагдах гэж байгаа юм байна. Хэлэлцээрийн энэ танилцуулга дээр Бүгд Найрамдах Казахстан Улсад 1998 он хүртэл хэлэлцээрт хамрах хүрээг нь бичээд 98 оноос хойших хамрах хүрээг нь хэлэлцээрт би олохгүй байна. Тэрийг аль заалт дээр яаж ойлгох вэ?.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 3 номер.

А.Хишигбаяр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Хишигбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ хэлэлцээрээр болохоороо бас 1998 оноос өмнөх харилцаа, 1998 оноос хойших харилцааг бол зохицуулж байгаа. Казахстан Улс бол нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын олон давхар тогтолцоотой байгаа. Тэгээд 1998 оноос хойш бол бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжсэн байгаа. Тэгэхээр 1998 оноос

өмнө шимтгэл төлсөн ажилласан хугацааг аль оронд амьдарч байгаагаасаа хамаараад тухайн орондоо яг ажиллаж байсан, амьдарч байсан, шимтгэл төлсөн гэдгээр аваад, 1998 оноос хойшхыг нь бол магадгүй Монгол Улсын иргэн Казахстан Улсад 1998 оноос хойш шимтгэл төлсөн байх юм бол Казахстан улсаасаа тухайн шимтгэл төлсөн хугацаандаа ногдох тэтгэврийг Монгол Улсдаа шууд авч байхаар ийм зохицуулалт байгаа. 1998 оноос өмнөхийг нь бол Монгол Улсын иргэн Монголоосоо Казахстан улсад ажилласан жилээ Монгол Улсад ажилласнаар тооцуулаад, Монгол Улсаасаа тэтгэвэр авах ийм харилцаа байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл 1998 оноос хойш Казахстан Улсад Монгол Улсын иргэн тэнд шимтгэл төлсөн байх юм бол Казахстан улсаас тэтгэвэр тогтоолгож авах эрх нь нээгдэж байгаа.

12.33 цаг.

2 дахь асуудал. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” асуудлыг хэлэлцье.

Бүрэлдэхүүнтэй холбогдуулаад би бас Улсын Их Хурлын тухай хуулийн зүйл заалтуудыг бас та бүхэнд танилцуулъя. Ямар ч Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтад Байнгын болон дэд, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд хуульд заасны дагуу орох, гарах, гишүүн үйл ажиллагаа явуулж байгаа 1-ээс илүү хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд ажиллахгүй гэж заасан байна. Ингээд Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтад Байнгын, дэд, хянан шалгах Түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх гэж заасан байгаа юм байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулах юм байна. Санал хураалтыг явуулъя. Гишүүд бэлтгэлтэй байгаарай. Санал хураалт. 85,7 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай” хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Сая өмнөх асуудалтай холбогдуулаад энэ асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргэх юм байна. Ажлын албаныхан бас анхаараад аваарай.

Ингээд Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаан Байнгын хорооны гаргасан гэсэн санал, дүгнэлтийг үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална гэж заасан байгаа юм. Ингээд дэд хорооны бүрэлдэхүүнд орох гишүүдийн нэрсийг танилцуулъя. Албан бичгээр нь би уншаад танилцуулчихъя. Холбогдох бүлэг болоод Улсын Их Хуралд суудалтай намуудаас нэрсийн саналыг ирүүлсэн байгаа.

Нэгдүгээрх нь 2024 оны 8 сарын 15-нд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалан танаа гээд санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт болон өөрийн хүсэлтийг нь үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр нарыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд хуваарилах, гишүүнээр орох саналыг хүргүүлж байна. Бүлгийн дарга Мөнхбаатар гэсэн байна.

2 дахь нь Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг дэд хорооны бүрэлдэхүүнд санал хүргүүлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь заалтын дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны харьяанд байх Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Х.Тэмүжин нарыг хуваарилах саналыг хүргүүлж байна. Бүлгийн дарга Цогтгэрэл гэсэн байна.

Гуравдугаарх нь Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын Номтойбаяр санал хүргүүлэх тухай.

Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.1.5-д заасныг үндэслэн Тусгай хяналтын дэд хороонд орох хүсэлттэй байх тул холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг Улсын Их Хурлын дарга Дашизэвгийн Амарбаясгаланд гаргасан байна.

Дараагийнх нь Монгол Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын дарга Дашизэвгийн Амарбаясгалан танаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүний хувьд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6 Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.5-д заасны дагуу

Тусгай хяналтын дэд хорооны гишүүн болон даргын үүргийг гүйцэтгэх хүсэлтэй байгаагаа үүгээр илэрхийлж байх тул хэлэлцэж өгөхийг хүсье гэсэн Батбаатар гишүүний 8 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын дарга Дашизэвгийн Амарбаясгалан даргад хүргүүлээд, наашаа цохолттойгоор орж ирсэн бичиг байна.

Сая би Цогтгэрэл даргаас ирсэн бичгийг танилцуулсан. Ингээд 8 сарын 19 Амарбаясгалан даргад хүргүүлээд, Амарбаясгалан даргын цохолттойгоор манай Байнгын хороонд хүргүүлсэн байгаа. Энэ дээр бол Ганбат, Тэмүжин нарыг гэж хуваарилах саналыг хүргэсэн байна. Ямар ч байсан ингээд Их Хурлын тухай хуулийн 30.1.6 дахь заалтад Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх гэгчихсэнээрээ өмнөх бичиг нь ингээд явах нь байна шүү. Сүүлд ирсэн нь бол ямар нэг байдлаар зөвшилцсөн шууд сая ингэж орж ирсэн байна. Ямар нэг байдлаар цохогдож орж ирээгүй байна. Ингээд ийм саналууд 2 бүлэг болоод 2 гишүүнээс бас ирсэн байгаад байгаа.

Дэд хорооны бүрэлдэхүүний талаар асуулт асуух гишүүд байна уу. Үг хэлэх. Ж.Энхбаяр гишүүн, Батбаатар гишүүн, Сайнзориг. Сайнзориг гишүүнээр тасалла. Ж.Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Тусгай хяналтын дэд хороо Улсын Их Хурал доторх онцгой ийм дэд хороо. Нөгөө талаас дэд хороо байгуулах, ялангуяа тусгай хяналтын дэд хороо дээр бүлгүүдийн саналыг албан ёсоор авч зөвшилцөж оруулдаг. Бүлэг байгуулаагүй улс төрийн нам болон Улсын Их Хурлын гишүүн өөрийн хүсэлтээр Байнгын хороо, дэд хороонд орох нь хязгаарлагддаг. Энийг манай гишүүд их сайн ойлгох хэрэгтэй. Яагаад гэвэл улсын онц чухал, маш нууц, гадаад болон дотоод аюулгүй байдалтай холбоотой асуудлууд энд хэлэлцдэг. Тэгэхээр улс төрийн бүлгүүд хариуцлага

хүлээдгийн хувьд бодлогоор яг энэ салбарт тогтвортой, удаан ажилласан, ялангуяа Хууль зүйн сайд хийж байсан, Гадаад яамны сайд хийж байсан, Батлан хамгаалахын сайд хийж байсан буюу яг энэ онц чухал, маш нууцтай харилцаж байсан, нууцын баталгаа гаргасан, нөгөө талаар бүх түвшинд шалгагдсан гэж байдаг. Тусгай албаны шалгалтад орсон, бас хариуцлага хүлээхээ батлан илэрхийлсэн ийм улсуудаар бүрдүүлж явдаг учиртай байдаг юм. Тэгэхээр бүлгүүдээс ирсэн саналын дагуу асуудалд хандах ёстой.

Тийм болохоор би бол өнөөдөр Улсын Их Хуралд бүлэг байгуулах хэмжээнд байгаа Монгол Ардын намын бүлгийн санал, Ардчилсан намын бүлгийн санал дээр тулгуурлаж ирсэн 5 хүний хүрээнд дэд хороог байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ асуудлаар санал хураалгаж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Горимын санал гаргаж байна гэсэн үг. Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Саяын Энхбаяр гишүүний хэлсэн саналтай ер нь бол зөрж байна. Сайд хэлснээр төрийн аюулгүй байдал, Монгол Улсын тусгаар тогтнолын асуудлыг ишийддэг зүйл байхгүй. Өмнөх магадгүй зарим гишүүд дээр болно, болохгүй гэдэг байдлаар ярьж байгаа бол энэ бол угаасаа зарчим нь буруу юм. Монгол Улсад үйл аж үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намуудын дарга нарыг улс орны тусгаар тогтнолд аюул учруулах этгээд бүхий шалгагдаагүй этгээд гэж хэлдэг нь туйлын буруу.

Миний бие 20 жилийн өмнө өөрөөс чинь өмнө Их Хурлын гишүүн, Ерөнхий сайдын зөвлөх хийж байсан. Тэгэхээр нөгөө тусгай шалгагдсан хүмүүс ордог юм. Бусад хүмүүс ордоггүй юм гэж хэлсэн учраас энийг тодруулж хэлэх нь зүйтэй.

Дараагийн асуудал нь юу гэхээр улс төрийн намууд төрийн сонгуульд орохдоо мөрийн хөтөлбөрөө гаргаж, төрийн эрх барих сонгуульд иргэд сонгогчдоос санал авдаг. Нэг бол тэр үед нь хязгаарлах хэрэгтэй. Энэ хүмүүс Монгол Улсын төрийн өндөр эрх, Улсын Их Хуралд нэр дэвшиж, сонгуульд оролцох эрхгүй юм гэдгийг хязгаарлах хэрэгтэй. Дээрээс нь Улсын Их Хурал 1 зүйлийг ойлгодог баймаар байна. Улсын Их Хурал бол ард түмний төлөөлөл. Улсын Их Хуралд байгаа олонх нь Засгийн газрыг бүрдүүлдэг, Улсын Их Хурал өөрөө Засгийн газар биш. Ард түмний төлөөлөл гэдгээ ойлгох хэрэгтэй. Тийм болохоор сая 7 нэр бол орж ирэхдээ Их Хурлын даргатай зөвшилцөөд орж ирж байна гэж үзэж байна. Орж ирсэн байна гэж ойлгож байгаа. Унисан учраас. Яах вэ санал хураахад мэдээж 110 намын бүлэг нь өөрөө олонх учраас асуудалгүй кнопоо дараад гарчих байх. Тэгэхдээ ийм зарчмын зөрүүтэй бөгөөд өөр утга агуулгаар асуудалд хандахгүй байхыг та бүхнээс бас хүсэж байна. Уг нь бол Улсын Их Хурал маань ард түмний төлөөлөл учраас энэ улс төрийн намуудын дарга нар, эвслийн дарга нар оролцъё гэсэн энэ зүйл дээр хойш нь татаж хэлэх шаардлагагүй байх. Засгийн газар болон Байнгын хороон дарга, Тусгай хяналтын дэд хороонд Засгийн газрын гишүүн, Байнгын хорооны дарга тусгай хяналтын дэд хороо нь давхар байх нь тийм зөв зүйл бас биш гэж бодож байна. Нэрээ татаад авчихвал дээр дээ.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн үг хэллээ. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би сая Байнгын хорооны даргын танилцуулгаас харахад энэ бас тусгай хяналтын дэд хорооны бас бүрэлдэхүүнд оръё гэсэн нам, эвсэл нэлээдгүй байгаа юм байна. Тэгэхдээ ер нь зүгээр их цомхон байх нь зөв байх гэж бодож байгаа юм. Энд бас Монгол Улсын нууцын асуудал, хил хамгаалалтын асуудал, эргээд энэ гүйцэтгэх

ажиллагааны бүх нарийн ширийн зүйлүүд бас явагддаг. Мэдээж энэ дээр ирэх 4 жилүүд дээр бас туршилагатай хүмүүс байх нь зөв. Ер нь зүгээр яах вэ, сая Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч орсон байж байгаа юм. Гүйцэтгэх ажлын хуулийг шинэчилнэ. Эргээд энэ төрийн нууцын хуулийг бас нэг жоохон сайжруулах асуудал бас яригдаж байгаа. Маш олон төрийн нууцын хуулиудын халхавчилж бас мэдээлэл ил тод бус болчихоод байна гэдэг зүйл бас байгаа. Тэгэхээр энэ Тусгай хяналтын дэд хороо манай Байнгын хорооны бас ирэх 4 жил дэх бас үүрэг оролцоо нэлээн чухал байгаа. Эргээд бас энийгээ бодсон ч гэсэн цомхон хүрээнд байхгүй бол аль аливаа хэрэг төвөгт бас орооцолдож байгаагүй хүмүүс ормоор байна. Зарим хүмүүс чинь бол бас өөрсдөө оръё гээд бас нам эвслээсээ төлөөлөөд бичгээ өгсөн байна. Урьд нь Батбаатар дарга аа, би үгээ хэлж байна. Ийм байна. Тэгэхээр би бас Байнгын хороод дээрээс бас зарчмын хувьд сая Энхбаяр гишүүн хэлж байна шүү дээ. Ийм цомхон байдлаараа бас яг Улсын Их Хуралд бас суудалтай, бүлэг байгуулах хэмжээнд байгаа энэ хэмжээндээ бас энэ Тусгай хяналтын дэд хороогоо байгуулаад явах нь зүйтэй. Бас хэт өргөжүүлж болохгүй. Энэ сүүлдээ ингэх юм бол бас дотоодын ч янз бүрийн үл ойлгогчид гарахыг бас үгүйсгэхгүй. Тийм учраас энийгээ цомхон байлга. Ирэх жилүүдэд бас энэ орох хүмүүс маань бас хариуцлагатай байгаа шүү гэдэг зүйлийг би хэлж байгаа. Төрийн нууцын хуулийг сайжруулахад бас зайлиггүй илүү их манлайлалтай бөгөөд яг нарийн дүгнэлтээ гаргаж ажиллах хэрэгтэй байна. Гүйцэтгэх ажлын хуулийг улс орны яг тагнуулын үйл ажиллагаа болон гэмт хэрэг зөрчлийг таслан зохих гэдэг юм уу, илрүүлэх чиглэлийн гүйцэтгэх ажлыг нууц мөрдөн шалгах ажиллагааг бас зааглах асуудал байж байгаа. Маш хариуцлагатай ийм бас заагууд дээр ажиллах хүмүүс байгаа. Тийм учраас би энэ дээр бас маш цомхон бөгөөд бас жоохон туршилагатай, аливаа

юмны наана цааныг бас учирлах тэр хүмүүс ороосой. Хамгийн гол нь аливаа зүйлд нэр холбогдсон хүмүүс шууд нэрээ татаад авчих хэрэгтэй л гэдэг зүйлийг би бас хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Сая 2 гишүүн горимын санал гаргаж байна. Ж.Энхбаяр гишүүн, Сайнзориг гишүүд. Батбаатар гишүүн бас горимын санал гаргасан. Тэгэхээр нэгдүгээрх нь горимын санал бол дэд хорооны бүрэлдэхүүний тоог 5-аар тогтё гэсэн саналыг Ж.Энхбаяр гишүүн гаргасан байгаа. Сайнзориг гишүүнийх ч гэсэн бас утга агуулга, зарчмын хувьд яг адилхан болчихлоо гэж үзэж байна. Батбаатар гишүүнийх бол бас тэгээд ерөнхийдөө сая тэгвэл Ж.Энхбаяр гишүүн болоод Сайнзориг гишүүдийн саналаар санал хураалтыг явуулах нь байна гэсэн үг ойлгогдох нь зөв үү. Эхний ээлжид бүрэлдэхүүнийхээ тоог тогтоох асуудал, горимын санал. Тэгээд дараа нь нэрсээ дахиж уншиж, танилцуулаад ингээд явъя.

Тэгээд дэд хорооны бүрэлдэхүүний 5-аар тогтё гэсэн горимын саналыг бас 2 гишүүн гаргасан байна. Энэ горимын саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Санал хураалт 70,6 хувиар дэмжигдсэн байна. Энэ санал дэмжигдсэн учраас нийт ирсэн нэрс дээр санал хураалт явагдана. Тэгэхээр нэрсийг нь би дахиад уншаад танилцуулаадахъя. Гишүүд нэрсийг танилцуулъя. Тэгээд санал хураалтыг хувь хүн бүрээр санал хураалт явуулах учраас нууцаар санал хураалт явуулна. Тэгээд дарааллаар нь бас манай Байнгын хорооныхон нэрсийн жагсаалтыг бас бэлтгээрэй. Монгол Ардын намын бүлгээс 8 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн, санал хүргүүлэх тухай. Ингээд Д.Цогтбаатар, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр нарыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд хуваарилах гишүүнээр оруулах саналыг хүргүүлж байна гэсэн ийм бичиг бас ирсэн байна.

Хоёрдугаарх нь Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 8 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн гээд байгаа. 01/21 гэсэн дугаартай. Дэд хорооны бүрэлдэхүүний санал хүргүүлэх тухай гээд, Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Х.Тэмүүжин нарыг хуваарилах саналыг хүргүүлж байна гээд энэ 8 дугаар сард ирүүлээд Амарбаясгалан дарга наашаагаа 19-нд цохисон ийм бичиг байна. Сая давхар би бас дахиад нэг бичгийг уншаад танилцуулчихъя.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 10 сарын 16-ны өдөр буюу өнөөдөр 01/37 гэсэн дугаартай, Дэд хорооны бүрэлдэхүүнд санал хүргүүлэх тухай.

27.7 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны харьяанд хамаарах дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, О.Амгаланбаатар нарыг томилуулах саналыг хүргүүлж байна гэсэн тамгатай бичиг орж ирсэн. Одоогоор бол цохолт нь орж ирээгүй ийм бичиг ирсэн байна. Зөвшилцөөгүй гэсэн үг Улсын Их Хурлын даргатай гэсэн үг.. Тэгэхээр Улсын Их Хурлын даргаас бол цохогдож орж ирээгүй, зөвшилцөөгүй бичиг байна л гэсэн. Хууль зөрчих учраас, одоогийн байдлаар бол цохогдож орж ирээгүй байна шүү гэдэг зүйлийг танилцуулъя.

Дараагийнх нь он дарааллаараа 8 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын Номтойбаяраас Улсын Их Хурлын дарга Дашизэвгийн Амарбаясгалан танаа гээд, ингээд Тусгай хяналтын дэд хороонд орох хүсэлтэй байх тул холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

Дараагийнх нь Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар гишүүнээс Монгол Улсын Их Хурлын дарга

Дашизэвгийн Амарбаясгалан танаа гээд. Ингээд Тусгай хяналтын дэд хорооны гишүүн болон даргын үүргийг гүйцэтгэх хүсэлтэй байгаагаа үүгээр илэрхийлж байх тул хэлэлцүүлж өгөхийг хүсье гэсэн ийм хүсэлт байна. Одоогоор яг албан ёсоор зөвшилцөөд орж ирсэн нь бол ингээд 7 гишүүний нэрс ирсэн байна. 2 намын бүлгээс, 2 гишүүнээс гэсэн ийм 7 нэрстэй байгаад байна. Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Их Хурлын даргатай зөвшилцсөн нэрийг, бүрэлдэхүүн тоог нь өөрчилдөг нь тэгээд зөв болсон юм уу даа. Нэг дэх нь.

2-т нь одоо энэ Тусгай хяналтын дэд хороо гээд хариуцлагатай, хэрэг төвөгт орооцолдоогүй тийм хүмүүс байх ёстой гээд гишүүд үгэн дотроо хэлээд байна. Шалгагдсан хүмүүс байх ёстой гэж хэлээд байна. Яах вэ Ерөнхий сайдын яг энэ асуудлыг хариуцсан зөвлөхөөр бас ажиллаж байсан л даа. 8, 9 жилийн өмнө. Тэгэхээр нөгөө тэр үед шалгагдаагүй байсан юм байлгүй. Нэг бол өмнө нь шалгагдаагүй байсан юм байлгүй. Ер нь ойлгохгүй байгаа. Хэрвээ шалгагдаагүй, асуудалтай гишүүд байгаа гэж үзэж байгаа бол нэрээр нь хэлэхгүй бол хаяг нь буруу яваад байна. Сайнзориг гишүүн ээ тайлбар хэлээрэй.

Дээрээс нь энэ Тусгай хяналтын дэд хороонд орёе гээд байж байгаа Цогтбаатар, Номтойбаяр гишүүд энд бас алга байна. Санал хураалтад орохын өмнө. Санал хураалтад гишүүдийн нэрийг оруулахад байхгүй байгаа гишүүний нэрийг санал хураалтад оруулах нь зөв юм уу Байнгын хорооны даргаас асууж байна.

Дээрээс нь Ардчилсан намын бүлгээс Тэмүүжингээ хасаад, Амгаланбаатар гээд нэрийг нь оруулаад ирлээ. Энд Тэмүүжин гишүүн нь энэ зааланд сууж байна. Зөвшөөрөөд байгаа юм уу, үгүйсгээд байгаа юм уу. Энэ эд нарыг нэг жоохон тодорхой болгоод,

хариултыг нь авчихвал зүгээр байна. Байхгүй их л чухал хүмүүс ордог, туйлын шалгагдсан жинхэнэ чекистүүд ордог гэдэг үг хэлсэн учраас уг нь хуучны ойлголт л доо. Тэгж хэлсэн учраас үгүй ээ үгүй, Ганбат гишүүнээ тэндээс хэлсэн байхгүй юу. Хүн үг хэлэхдээ тэгж хэлсэн. Үгүй ээ тийшээ ярьж байна. Өөрт чинь зориулж хэлээгүй. Өөрт чинь зориулж хэлээгүй. Тийм болохоор тийм болохоор энэ асуудлуудыг жишээ нь тодруулаад хариулж өгнө үү. Байнгын хороон дарга хариулах байх. Цогтбаатар, Тэмүүжин, Ганбат гишүүнийг хүртэл хасчихсан л байна лээ шүү дээ. Ардчилсан намын сая сүүлд ирсэн бичиг дээр. Энэ чинь холион бантан болчихлоо. Тэмүүжинг хасчихсан байсан уу.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүний асуултад бас хариулъя. Тэгээд Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.1.6 дахь заалтаар яалт ч үгүй л түр хорооны бүрэлдэхүүний асуудлыг Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх гэж заасан байгаа. Тэгээд тэр хүрээндээ зөвшилцөнө гэдэг нь тодорхой хэмжээнд албан бичгээр албан ёсоор хандаад, тэр нь түүгээрээ наашаа цохогдоод орж ирсэн асуудлыг л бид нар зөвшилцөх гэж ойлгож байна гэж харж байгаа. Тэгээд Улсын Их Хурлын дарга бол өөрөө зөвшилцөөд, тэр дээр нь цохолт хийгээд Байнгын хороонд хуваарилсан. Ингээд энэ дарааллаар нь уншиж танилцуулж байна л гэж ойлгоорой. Тэгээд саяын Ардчилсан намын тэр уншсан, давхцаж орж ирсэн гэдэг нэрсийн асуудал яг албан ёсны зөвшилцсөн бичиг нь Ганбат, Тэмүүжин гэсэн нэрс дээрээ байна. Яг одоогийн байдлаар ямар нэг байдлаар Улсын Их Хурлын дарга дээрээс бол сүүлийнх нь цохолттойгоор орж ирсэн байхгүй байгаад байна. Тэгэхээр би Улсын Их Хурлынхаа хуулийг бариад л зөвшилцөх гэдэг дэгээрээ л явахаас өөр бол арга байхгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ чинь хувь хүнтэй холбоотой асуудал учраас санал хураалтыг нууцаар явуулж таарна. Бүлгийн санал учраас илээр явна.

Ойлголоо. Тэгвэл эхнээс нь саналуудаа хураагаад явна гэсэн үг болох нь байна.

Бүрэлдэхүүний тоог бол сая гишүүд горимын санал гаргаад 5-аар тогтоосон байгаа. Ингээд ирсэн бичгийн дарааллаар явах нь байна шүү.

Амгаланбаатар гишүүн ээ. Нэгд энэ дэд хороогоо бид нар яаралтай байгуулах ёстой. Төсөв өргөн баригдсан. Тэгээд Тусгай хяналтын дэд хороо угаасаа энэ хууль хяналтын байгууллагууд, харьяалах, хамаарах байгууллагуудынхаа төсвийг бас хянаж нягтлах хуулийн хугацаатай байгаа юм. Сая Их хурлын даргаас манай Байнгын хороонд судлахаар бичиг цохолт орж ирсэн байна. Тэгэхээр өмнөх бичиг нь хүчингүй боллоо гэж ойлголоо шүү. Би өгөөдөхье энэ дээрээ болохоор сая өнөөдрийн дугаартай 01/37 дугаартай Ганбат, Амгаланбаатар нарыг томилуулах саналыг үүгээр хүргүүлж байна гэсэн ийм цохолттой. Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Энд их сонин юм болж байна. Ер нь бол сая энэ Тусгай хяналтын дэд хороог байгуулах асуудал дээр парламент дотроо юмыг шийдэж чадахаа больсны нэг том илэрхийлэл одоо энд гарч ирж байгаа юм. Хэнийг энэ дэд хороонд оруулах, оруулахгүйг парламентаас гаднаас захиалдаг болчхож. Бүр тухайлбал гүйцэтгэх ажил явуулдаг, энэ чиглэлийнхээ үйл ажиллагаанд парламентад хянуулахгүй гэж зорьдог ийм байгууллагууд энэ дэд хороонд ийм хүн баймааргүй байна. Манай байгууллага дээр энэ хүн нь илүү талтай учраас өөрсдийн байгууллагыг төлөөлж энэ хүнийг оруулъя гэдэг бүр захиалга өгчхөж. Тэгээд захиалга өгч байгаа нь юу вэ гэхээр тухайн байгууллагад шалгагдаж байсан, хуучин бол төмсөгдүүлж байсан гэж улс төрчид хоорондоо ярьдаг. Ийм хүмүүсийг оруулмаар байна. Бид хянагдмааргүй байна. Ийм хэл амтай, ийм хүн ороод ирвэл манай байгууллага жсоохон эвгүй болно. Байгууллага нь эвгүй

болохгүй л дээ. Дарга нь эвгүй болно гэж байгаа байхгүй юу.

Тэгээд ийм тоглолт хийж байгаа учраас яг энэ асуудал дээр Ардчилсан намын бүлэг завсарлага авч байна. Завсарлагаа өгчих. Тэгээд бид нар хоорондоо яриадахъя.

2-т нь парламент парламент шиг байх ёстой. Жоохон зоригтой байх ёстой. Парламентын хяналтыг сайжруулъя гэж бодож байгаа бол гүйцэтгэх эрх мэдлийн дотор байгаа агентуудын захиалгыг гүйцэтгэдэг парламент байж болохгүй. Одоо жоохон зарчимтай, хариуцлагатай ярих ёстой шүү. Энийг жоохон хатуу хэлье.

Г.Тэмүүлэн: Ардчилсан намын бүлгийн дэд дарга Тэмүүжин дарга завсарлага авах санал гаргасан учраас 1 цагийн завсарлага. 1 цаг. Ирц хэвээрээ.

ЗАВСАРЛАГА.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны хуралдаанаа үргэлжлүүлэе. Ирц хуучнаараа байгаа. Ардчилсан намын бүлгээс 1 цагийн завсарлага авсан байгаа. Завсарлагын цаг дууссан байна. Бүлгийн дэд дарга Тэмүүжин дарга үг хэлэх үү. Тэмүүжин дарга.

Х.Тэмүүжин: Завсарлага дууссан. 2 зүйлийг хэлэх хэрэгцээ байна.

1 дүгээрт түрүүн би хэлсэн. Парламент Улсын Их Хурал манайх бол парламентын засаглал бүхий улс. Улсын Их Хурлын гаднаас нөлөөлөлгүй бүрэн эрхтэй байна гэдэг энэ үзүүлэлт бол Монгол Улсын бүрэн эрхт байдлын хамгийн чухал үзүүлэлт. Ард түмнээсээ сонгогдсон, тэднийг төлөөлж байгаа институц нь өөрөө гүйцэтгэх эрх мэдэл байна уу, гаднын байгууллага байна уу, гадаад улс орон байна уу, эсвэл хувийн аж ахуйн нэгж байна уу тэдний явцуу хуулиас давсан ашиг сонирхлын нөлөөнд автахгүй байх, бие дааж дотоод зохион

байгуулалтаа хийдэг байх, дотоод хяналт, зохион байгуулалт, чиг үүргээ хэн нэгний гаднаас огт сонгогддоггүй этгээдүүдийн гар хөлийн үзүүрээр шийдэгддэггүй байх гэдэг бол парламентын хамгийн чухал шинж чанар. Тэгээд энэ шинж чанар дээрээ бол Улсын Их Хуралд байгаа гишүүд нэлээн хатуу зогсож байх ёстой.

2-т нь манай парламентын чиг үүргийн дотоод хуваарилалт дээр бас жоохон алдаа гажууд байгаа. Тухайлбал хууль сахиулах болон гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бол Хууль зүйн байнгын хорооны үндсэн чиг үүрэг байж байдаг. Гэтэл энэ байгууллагуудын нууц мөрдөн шалгах гэж хэлдэг. Шүүхийн зөвшөөрөлтэй заримдаа явагддаг. Заримдаа шүүхийн зөвшөөрөлгүй явагдаж байгаа. Энэ үйл ажиллагааны хяналт тэр Байнгын хороо дээрээ байхгүй байгаа нь өөрөө манайд эрүү шүүлт хавтгайрсан, хүний эрхийн зөрчил түгээмэл болж хувирсан жирийн үзэгдэл шиг. Тэгээд хуулийн байгууллагууд нь энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь иргэд тийм үйлдэл хийхэд гэмт хэрэг гэж үздэг байхад хуулийн байгууллага тийм үйлдэл хийхэд огт гэмт хэрэг биш, энгийн зүйл шиг ингээд явдаг болчихсон тийм соёл тогтчихсон. Тэгээд энэ соёлыг эвдэхэд парламентын хяналтыг сайжруулахад Аюулгүй байдлын байнгын хороо болон энэ өнөөдрийн Тусгай хяналтын дэд хороо гэж ярьж байгаа энэ 2 институц бол маш том чиг үүрэгтэй. Энэ нь ямар чиг үүрэгтэй вэ гэхээр өөртөө олгогдчихсон байгаа илүү эрх мэдлээ зохистой хэрэгжүүлэх ёстой Хууль зүйн байнгын хороо руу шилжүүлж өгөх хэмжээний зориг гаргаасай гэж би хүсэж байгаа юм. 30 жил энэ Байнгын хороо болон Тусгай хяналтын дэд хороон дээр явлаа. Гэтэл иргэдийн дунд, бизнес эрхлэгчдийн дунд, улс төрчдийн дунд, шийдвэр гаргагчдын дунд утсаар ярихаасаа айдаг, эх захгүй гүйцэтгэх ажлын үйл ажиллагаанд өртдөг, хувийн мэдээллүүд нь хэн нэгэн албан

тушаалтны сейфт хадгалагддаг. Түүгээрээ барьцаалагдаад ажлаа ч шударга, хариуцлагатай хийж чадахгүй, хэн нэгний захиа даалгаврыг гүйцэтгэхгүй бол тэр хэмжээнд өөрөө аюултай байдалд орлоо гэж айдастай байдаг. Энэ цаг хугацааг зогсооё гэвэл Аюулгүй байдал, гадаад байдлын байнгын хороо бол зоригтой, хаттай, дээр нь эрүүл саруулаар харах ёстой. Тусгай хяналтын дэд хороо мөн адил. Тусгай хяналтын дэд хороонд бол тагнуул болон армийн чиг үүрэг бол бүр үлдэх ёстой. Монгол Улсын иргэд рүү үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн хүрээнд тийшишгээ тусгай техник хэрэгсэл болон хүч нөөцөөр халдаж байгаа тэр байгууллагууд бол Монгол Улсын иргэний үндсэн эрхийн хүрээнд Хууль зүйн байнгын хорооны хяналтад бүрэн орох ёстой. Тэгээд ийм шинэтгэлийг зохимжтойгоор хийгээрэй. Тэгээд өнөөдрийн санал хураалтууд болон өнөөдрийн шийдлүүд энэ шинэтгэлийн эхний алхам байх гэж Ардчилсан намын бүлэг бол үзэж байна. Тэгээд сүүлийн санал цаас буюу сүүлд явуулсан албан тоотод байгаа нэрсээр Байнгын хороо дээр санал хурааж өгөхийг Ардчилсан намын бүлгээс хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүнд баярлалаа. Ингээд санал хураалтыг явуулж эхэлье. Ирсэн дарааллаараа гээд явж байгааг та бүхэн бас ойлгоорой.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд орох талаар ирсэн байгаа саналууд дээр нэр дэвшигч дэвшигч тус бүрээр санал хураалтыг явуулахаар байгаа.

Ингээд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Горим гаргаж болно л доо. Санал хураалт. Цогтбаатар гишүүнийг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор

санал хураалт явуулж байна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Жангабыл гишүүнийх ажилласангүй, Тэмүүжин гишүүнийх ажилласангүй. Зөвшөөрснөөр орсон уу. Хоёулаа дэмжсэн зөвшөөрөгдсөнөөр орсон байна. Хоёуланг нь протоколд тусгая. Ингээд 18-14 гишүүн дэмжсэн байна. Протоколд тусгаад аваарай.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 13 гишүүн. Ж.Энхбаяр гишүүн 18-14 гишүүн дэмжсэн байна. Протокол дэмжсэнээр бас Тэмүүжин гишүүнийг оруулъя.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 18-14 гишүүн дэмжсэн байна. 77,8 хувиар дэмжигдлээ.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18-13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар дэмжигдсэн байна. Сайнзориг гишүүн бас төхөөрөмж нь ажиллаагүй. 18-14, 77,8 хувиар дэмжигдлээ.

Тусгай хяналтын дэд хороонд Ардчилсан намын бүлгээс санал болгосон Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 18-12, 66,7 хувиар дэмжигдсэн байна.

Дараагийнх нь Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах санал ирүүлсэн. Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураах юм

байна. Санал хураалт. Санал хураалтыг дахиад явуулъя. Саяынх төхөөрөмж ажилласангүй.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд орох санал ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Төхөөрөмж яасан бол. Ажлын алба доошоо хэлээрэй. Төхөөрөмж бэлэн болсон уу. Бэлэн болохоор наашаа хэлээрэй.

Одоо санал хураалтыг явуулъя. Тусгай хяналтын дэд хороон бүрэлдэхүүнд орох санал ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Номтойбаярыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулах нь байна. Санал хураалт. 18-4 зөвшөөрч, дэмжигдсэнгүй. 18-14 татгалзсан байна.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд орох санал ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарыг оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 18-5 дэмжиж, 18-13 татгалзсан байна. Ингээд дэмжигдсэнгүй.

Ингээд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дэг байхгүй л дээ. Та нэг горимын санал гээд байсан уу. Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Түрүүн Ж.Энхбаяр гишүүн, Сайнзориг гишүүд үг хэлээд, горимын санал хураалгаад, Тусгай хяналтын хорооны бүрэлдэхүүнийг 5 болгоё гэдэг тоон тухай ярьсан. Тэр дээр бас хэд хэдэн агуулгатай Их Хурлын гишүүдийн байр суурь илэрхийлэгдсэн. Тийм болохоор тэр дээр цөөнх болсон миний горимын саналыг яах юм бэ гээд асуугаад, энэ санал хураасан цөөнх болчихсон учраас чуулган дээр хураагдана энд бол ярихгүй гээд, тэгээд л орхичихсон шүү дээ. Протоколд бол уг нь тэгж орсон.

Үгүй ээ үгүй, би санал гаргаад миний саналыг хураагаагүй байхгүй юу. Энэ 5 бүрэлдэхүүнтэй гэдэг санал хураагдсан учраас тэр дээр нь санал хураагдаагүй шүү дээ. Өөр тоо гараагүй шүү дээ. Үгүй ээ, үгүй. 7 гээд хэлсэн шүү дээ. Тэр зөвшилцсөн тоо нь 7 байна. 7 хүний нэр орж ирлээ. Тэрүүгээр болохгүй юу. 5-аар эхэлж санал хураалгая гээд. Тэгэхээр чинь цөөнх болчихож байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй. Б.Энхбаяр аа, энэ чинь нөгөө эхлээд 7 гэдэг чинь орж ирээд, тэгээд түүгээрээ эхнийхээ саналаар саналаа хураахгүй шууд 5-аар нь хураачихсан шүү дээ.

Г.Тэмүүлэн: Ойлголоо Батбаатар гишүүн ээ. Сая нөгөө хуулийн төсөл дээр л зарчмын зөрүүтэй санал дээр л бид санал хураах юу байгаад байгаа. Түрүүн бол олонхоороо 5 байна гэдэг дээр санал хураалт явуулаад, тэр дээр олонхоороо дэмжигдчихсэн учраас таны саналыг яг агуулга нэг гэдгээрээ хураасанд тооцогдоод ингээд явчхаж байгаа юм.

Ингээд “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн байна уу. Алтаниагай гишүүн танилцуулъя. Алтаниагай гишүүн. Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

14.39 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ